



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/153

Өмнөдэлгэр сум

**Ойн цэвэрлэгээний арга хэмжээг
хэрэгжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.2 дахь заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн А/12 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр тус сумын Цагаан тэмээт гэх газар буюу ойн сангийн 459 дүгээр хэсэглэлийн 20, 22 дугаар ялгарал дахь 100 га талбайд ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг “Зоос булаг” ХХК-аар гүйцэтгүүлсүгэй.

2. Ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх талбайд цэвэрлэгээний ажил, цэвэрлэгээний огтлолтын арга хэмжээг хамтад хэрэгжүүлэх мод бэлтгэлийн талбай тусгаарлалт хийх, тухайн талбайгаас гарах нөөцийг тодорхойлох, нөөц ашиглах эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгох, тухайн талбайд өөрийн хөрөнгийн нөхөн сэргээх талбайн хэмжээг мод бэлтгэх гэрээнд тусган, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулахыг Хэнтий шинэс сум дундын ойн ангийн дарга (Б.Давхарбаяр)-т даалгасугай.

3. Ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх ажилд байнгын хяналт тавьж ажиллахыг байгаль хамгаалагч (С.Ууганбаяр), мод бэлтгэх эрхийн бичиг, мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч (Т.Чинхуяг) нарт тус тус даалгасугай.



Р.ЭНХТӨР